



## ШҮҮХИЙН ТОГТООЛ

2021 оны 01 сарын 14 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

### Ардчилсан намаас ирүүлсэн хүсэлтийг хэлэлцэх тухай

Монгол Улсын Дээд шүүхийн шүүх хуралдааныг Танхимын тэргүүн Х.Сонинбаяр даргалж, шүүгч П.Золзаяа, Г.Алтанчимэг нарын бүрэлдэхүүнтэй хийж, намын дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг бүртгүүлэх, цахим сан дахь мэдээлэлд залруулга хийлгэх, өөрчлөлт оруулах, улсын бүртгэлийн гэрчилгээнд өөрчлөлт оруулах, тамга, тэмдгийн хяналтын дугаар олгох талаар Улсын Дээд шүүхэд гаргасан Ардчилсан нам /АН/-ын хүсэлтийг хянан хэлэлцэв.

Шүүх хуралдаанд: Ардчилсан нам /АН/-с Ц.Туваан, Б.Мягмардаш, О.Алтангэрэл, Л.Батмөнх, Ш.Түвдэндорж, С.Эрдэнэ, Н.Ариунболд, И.Мөнхжаргал, Г.Батбаяр, А.Цэрэнбат нар, өмгөөлөгч Ж.Гантуяа, нарийн бичгийн дарга Х.Билгүүн нар оролцов.

ТОДОРХОЙЛОХ нь:

1. Ардчилсан нам /АН/-ын даргын үүрэг гүйцэтгэгч Ц.Туваан Улсын Дээд шүүхэд ирүүлсэн хүсэлтдээ: ...Ардчилсан намын Үндсэн дүрмийн 5.12.4.1-д заасны дагуу намын Их хурлын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 10/03 тоот тогтоолын хавсралтаар Ардчилсан намын “Үндсэн дүрмийн нэмэлт, өөрчлөлт”-ийг баталсан болно. Иймд Улс төрийн намын тухай хуулийн 9 дүгээр зүйл, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1, Улсын дээд шүүхийн хуралдааны дэгийн 9 /бүлэг/-т заасны дагуу Ардчилсан намын “Үндсэн дүрмийн нэмэлт, өөрчлөлт”-ийг бүртгэж өгнө үү гэжээ.

2. Ардчилсан нам /АН/-ын дарга С.Эрдэнэ Улсын Дээд шүүхэд ирүүлсэн хүсэлтдээ: ...Ардчилсан намаас Улс төрийн намын тухай хуулийн 21.2 дахь хэсгийг баримтлан Улсын Дээд шүүхэд 2020 оны 12 дугаар сарын 23-ны өдөр хүргүүлсэн АН-ын 2020 оны 12 дугаар сарын 18-аас 19-ний өдрүүдэд зохион байгуулсан гэх 10 дугаар Их хурлын тэмдэглэл, шийдвэр зэргийг буцаан татах хүсэлтийг гаргаж байна. Улсын Дээд шүүхэд хүргүүлсэн 10 дугаар Их хурлын бичиг баримтуудад Ардчилсан намыг төлөөлөн дарагдсан тамга хүчингүй болсон, төлөөлөх эрх бүхий хууль ёсны этгээдийн гарын үсэг зурагдаагүй зэрэг танай байгууллага хүлээн авч шийдвэрлэх боломжгүй нөхцөл байдал үүссэн тул 2020 оны 12 дугаар сарын 23-ны өдөр АН-аас хүргүүлсэн баримтуудыг дутагдалгүй бүрнээр нь хуульд нийцүүлэн буцаан ирүүлнэ үү гэжээ.

3. Ардчилсан нам /АН/-ын дарга С.Эрдэнэ Улсын Дээд шүүхэд ирүүлсэн хүсэлтдээ: ...Ардчилсан намын 2017 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 7 дугаар Их хурлын 03 дугаар тогтоолоор С.Эрдэнийг Ардчилсан намын даргаар сонгогдсоныг баталсан. Дээрх тогтоолыг Улсын Дээд шүүх 2017 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 01 дугаар тогтоолоор С.Эрдэнийг АН-ын даргаар бүртгэсэн. Гэтэл тус намын хэрэг эрхлэх газрын дарга гэх намыг төлөөлөх эрхгүй этгээд П.Нүрзэд нь намын даргын үүрэг гүйцэтгэгчээр Ц.Туваан томилогдсон мэтээр Улсын дээд шүүхэд хүсэлт хүргүүлж, улмаар цахим мэдээлэлд өөрчлөлт оруулсан байна. Иймд ямар хууль дүрэм, журмыг үндэслэн Улсын Дээд шүүхийн цахим сайтад иргэн Ц.Тувааныг АН-ын даргын үүрэг гүйцэтгэгч гэж тэмдэглэл үйлдсэнийг тогтоож, залруулж зөвтгөх арга хэмжээг хуулийн хүрээнд авч хариуг ирүүлнэ үү гэжээ.

4. Ардчилсан нам /АН/-ын даргын үүрэг гүйцэтгэгч Ц.Туваан Улсын Дээд шүүхэд ирүүлсэн хүсэлтдээ: ...Ардчилсан нам нь 2017 оны 03 дугаар сарын 03-ны өдөр Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газраас олгосон тамга, тэмдгийн 1117237845 хяналтын дугаартай тамгыг үйл ажиллагаандаа ашиглаж ирсэн. УБЕГ-ын хяналтын улсын байцаагчийн 2020 оны 6030 дугаартай дүгнэлтээр дээрх

хяналтын дугаартай АН-ын тамга тэмдгийг хүчингүй болгосон тул Ардчилсан нам уг тамгыг цаашид ашиглах боломжгүй болж, эрх бүхий байгууллагаас тамга, тэмдгийн хяналтын дугаарыг нөхөн авах шаардлага үүсээд байна. Иймд Ардчилсан намд тамга, тэмдгийн хяналтын дугаар олгож өгнө үү. Мөн намын Үндэсний бодлогын хорооны 2020 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 16/06 дугаар тогтоолоор Ц.Тувааныг намын даргын үүрэг гүйцэтгэгчээр томилж, бүртгүүлээд байгаа билээ. Иймд Ц.Тувааныг Ардчилсан намын даргын үүрэг гүйцэтгэгчээр томилогдсон бичилтийг Ардчилсан намын улсын бүртгэлийн гэрчилгээн дээр тэмдэглэж өгнө үү гэжээ.

5. Ардчилсан нам /АН/-ын Хэрэг эрхлэх газрын дарга П.Нүрээд Улсын Дээд шүүхэд ирүүлсэн хүсэлтдээ: ...Тус намын үндсэн дүрмийн 5.17.6 дахь заалтын дагуу дэд дарга Ц.Туваанд Ардчилсан намын даргын эрх, үүрэг шилжсэн. ҮБХ-ны 2020 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн XVI хуралдааны 16/06 тогтоолоор Ц.Тувааныг Ардчилсан намын даргын үүрэг гүйцэтгэгчээр батламжилж, Үндсэн дүрмийн 5.13.12.25 дахь заалтаар намын Х Их хуралд бэлтгэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Ц.Туваанд даалгасан. Дээрх ҮБХ-ны тогтоолын дагуу Ардчилсан нам Х Их хурлаа 2020 оны 12 дугаар сарын 18, 19-ний өдрүүдэд цахимаар хуралдуулж намын үндсэн дүрэмдээ нэмэлт, өөрчлөлт оруулсан. 2020 оны 12 дугаар сарын 23-ны өдөр Х их хурлаар хэлэлцэн баталсан үндсэн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг бүртгүүлэхээр 01/450 тоот албан бичиг, хавсралт материалуудыг Монгол Улсын дээд шүүхэд Монгол шуудангаар дамжуулан хүргүүлсэн. Бүртгэх ажиллагаа удааширч буй нь нийгэмд эргэлзээ төрүүлж, улмаар удахгүй болох Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд Ардчилсан намын оролцох оролцоонд саад болох хандлагатай байгаа тул хууль тогтоомжийн дагуу яаралтай бүртгэж, бидний ажилд туслалцаа үзүүлнэ үү гэжээ.

6. Ардчилсан нам /АН/-ын Хэрэг эрхлэх газрын даргын үүрэг гүйцэтгэгч А.Цэрэнбат Улсын Дээд шүүхэд ирүүлсэн хүсэлтдээ: ...Ардчилсан нам бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт хийгдэж өмнө хэрэглэж байсан 1117237845 дугаартай тамга, ХНТ0800 дугаартай тэмдэг нь Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хяналтын улсын байцаагчийн 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 6030 тоот дүгнэлт гарч хүчингүй болсон. Цаашид 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн 9020120477 дугаартай тамга, ХНТ4896 дугаартай тэмдгийг ашиглах тул та бүхэн архив, бичиг хэргийн мэдээллийн сандаа бүртгэж хамтран ажиллахыг хүсье гэжээ.

7. Ардчилсан нам /АН/-ын дарга С.Эрдэнэ Улсын Дээд шүүхэд ирүүлсэн хүсэлтдээ: ...Ардчилсан намын төлөөллийн төв байгууллага болох Үндэсний бодлогын хорооны хуралдаан 2021 оны 01 дүгээр сарын 10 -ны өдөр хуралдаж Ц.Туваанд Ардчилсан намын даргын үүргийг түр шилжүүлсэн 2020 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 16/06 тоот тогтоолыг хүчингүй болохыг тогтоож, Ц.Тувааныг Ардчилсан намын даргын түр орлон гүйцэтгэгчийн үүргээс чөлөөлсөн. Ардчилсан намын Үндсэн дүрмийн хорооны 2020 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 16 дугаар тогтоолоор намын дүрмийн холбогдох заалтын талаар тайлбар гаргасан. Тодруулбал: Ардчилсан намын дарга нь Үндсэн дүрмээр шинээр сонгогдож, бүрэн эрх нь баталгаажсан шинэ даргад эрх, үүргээ шилжүүлнэ гэсэн. Иймд Улсын дээд шүүхийн цахим бүртгэлд Ардчилсан намын дарга “Намын даргын үүрэг гүйцэтгэгч Ц.Туваан” гэснийг “Намын дарга С.Эрдэнэ” гэж өөрчилнө үү гэжээ.

8. Ардчилсан нам /АН/-ын даргын үүрэг гүйцэтгэгч Ц.Туваан Улсын Дээд шүүхэд ирүүлсэн хүсэлтдээ: ...Ардчилсан намд тамга, тэмдгийн хяналтын дугаар олгох, мөн Ц.Тувааныг Ардчилсан намын даргын үүрэг гүйцэтгэгчээр томилогдсон тухай бичилтийг Ардчилсан намын улсын бүртгэлийн гэрчилгээн дээр тэмдэглэж өгнө үү, гэх хүсэлтийг танайд 2021.01.04-ний өдрийн 01/01 тоот бичгээр гаргасан тул үүний хариуг 2021.01.12-ны өдрийн дотор бичгээр өгнө үү” гэжээ.

9. Ардчилсан нам /АН/-ын гишүүд гэсэн 84 хүний гарын үсэг бүхий Улсын дээд шүүхэд ирүүлсэн хүсэлтэд: ...Ардчилсан Намын 21 аймаг, 9 дүүргийн 1400 хүн 2020.12.18-нд 10 дугаар Их хурлаа зарлан хуралдуулсан. Харамсалтай нь АН-ын даргаар ажиллаж байсан С.Эрдэнэ Их хурлын шийдвэр гарснаас хойш АН-ыг хагалан бутаргах үйл ажиллагаа явуулж олон нийтийг төөрөгдүүлж байгаа үйлдлийг АН-ын гишүүд, 10 дугаар Их хурлын төлөөлөгчид бид эрс буруушааж байна. С.Эрдэнэ хууль бус үйлдлийнхээ хүрээнд танай байгууллагад хандан хүсэлт, албан тоотууд өгч байгааг цахим орчноос олж мэдлээ. Намын олон мянган гишүүд энэ талаар эсэргүүцлээ илэрхийлж, намын дүрмийн дагуу нэгэнт огцорсон С.Эрдэнэ хууль бус үйлдэлдээ Улсын Дээд шүүхийг татан оролцуулахаар

оролдож байгааг жигшин зэвүүцэж байна. Иймд цар тахлын хорионы үед орон нутгаас ирэх боломжгүй 10 дугаар Их хурлын нийт төлөөлөгчдийг төлөөлөн нийслэлийн 9 дүүргээс сонгогдсон төлөөлөгчид бид нэгэнт батлагдсан АН-ын дүрмийг бүртгэх үйл ажиллагаагаа Улсын дээд шүүх нь С.Эрдэнэ нарын болон эрх баригчдын аливаа нэг нөлөөгүй хуулийн дагуу шуурхай шийдвэрлэхийг хүсэж байна” гэжээ.

Хүсэлтэд: Нийт 325 хуудас баримт, 5 ширхэг CD-ыг хавсарган ирүүлсэн байна.

Хүсэлт болон хавсаргасан баримт, хуралдаанд гаргасан тайлбарыг судлан хэлэлцээд

#### ХЯНАВАЛ:

Нэг. Ардчилсан нам /АН/-ын даргын үүрэг гүйцэтгэгч Ц.Туваан тус намын дүрэмд оруулсан нэмэлт өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлэх хүсэлтийг 2020.12.24-ний өдөр Улсын Дээд шүүхэд гаргасан байна.

Тус намын Хэрэг эрхлэх газрын дарга П.Нүрзэдийн 2021.01.05-ны өдрийн 02/03 албан бичигт “намын дүрмийн өөрчлөлтийг яаралтай бүртгэж өгнө үү” гэсэн болон АН-ын 84 гишүүний гарын үсэг бүхий хүсэлтэд “...АН-ын дүрмийг бүртгэх үйл ажиллагааг... аливаа нэг нөлөөгүй хуулийн дагуу шуурхай шийдвэрлэх”-ийг хүссэн бөгөөд энэхүү 2 хүсэлт нь намын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулсныг бүртгүүлэх нэг агуулгатай хүсэлт гэж үзэв.

Намын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах хүсэлтийг хэлэлцээд дараах үндэслэлээр хүлээн авахаас татгалзав.

Улс төрийн намын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “намын дүрэм, мөрийн хөтөлбөр, тэдгээрт оруулсан нэмэлт, өөрчлөлт нь Үндсэн хууль, энэ хуультай нийцэж байгаа эсэхэд Улсын дээд шүүх хяналт тавина. Нам өөрийн дүрэм, мөрийн хөтөлбөртөө оруулсан өөрчлөлтийг 10 хоногийн дотор Улсын дээд шүүхэд бүртгүүлнэ.” гэж заажээ.

Улсын Дээд шүүх хуульд зааснаар ийнхүү хяналт тавихдаа тухайн намын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулж, хэлэлцэн баталсан үйл ажиллагаа болон шинэчлэн батлагдсан дүрмийн агуулга, утга санаа, үзэл баримтлал нь хууль тогтоомжид нийцсэн эсэхийг тогтооно.

Ардчилсан нам /АН/-ын 2018.12.05-ны өдрийн 9 дүгээр Их хурлаар нэмэлт, өөрчлөлт оруулсан намын дүрмийг Улсын дээд шүүх бүртгэж тогтоол гаргасан тул уг дүрэм тухайн намын үйл ажиллагаандаа баримтлах, дагаж мөрдөж, хэрэгжүүлэх үндсэн баримт бичиг нь болох юм.

Ардчилсан нам /АН/-ын даргын үүрэг гүйцэтгэгч Ц.Тувааны гаргасан хүсэлтэд, тус намын 10 дугаар ээлжит Их хурлын 2020.12.18-ны өдрийн 10/03 тоот тогтоолоор намын үндсэн дүрэмд өөрчлөлт оруулсан гэсэн бөгөөд тухайн Их хурлыг хуралдуулсан болон намын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцсэн, санал хураасан үйл явц нь Улс төрийн намын тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, хүчин төгөлдөр мөрдөгдөж буй намын дүрмийн зохицуулалтад бүрэн нийцээгүй байна. Үүнд:

1.1 Дүрмийн 5.12.4.1, 5.12.2-д намын Их хурлаар намын дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулахыг, Их хурлын ээлжит хуралдааныг дөрвөн жилд хоёроос доошгүй удаа хуралдуулах, Их хурлын ээлжит хуралдааныг Үндэсний бодлогын хорооны /цаашид ҮБХ/ нийт гишүүдийн ердийн олонхи /50-аас дээш хувь/-ийн саналаар эсвэл Намын дарга зарлан хуралдуулахаар тус тус заажээ.

Ардчилсан нам /АН/-ын даргын үүрэг гүйцэтгэгч Ц.Туваан 2020.12.11-ний өдөр А/19 тоот тушаал гаргаж, тус намын 10 дугаар ээлжит Их хурлыг 2020 оны 12 дугаар сарын 18, 19-ний өдрүүдэд цахимаар хуралдуулахаар зарласан байна.

Их хурлыг хуралдуулахаар зарласан Ц.Туваан намын даргыг төлөөлөх эрхтэй эсэх нь маргаантай, энэ талаар намын дотоод хүрээнд маргаантай асуудал үүссэн байна. Иймд Их хурлыг дүрэмд заасны дагуу эрх бүхий этгээд зарласан эсэхийг дүгнэх боломжгүй байна.

1.2 Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хүсэлтийг шүүх, хуралдаанаар нэгэнт хэлэлцсэн учир дараах зөрчлүүд тогтоогдсоныг дурдах нь зүйтэй байна.

а/ Хүсэлт гаргагч талуудын тайлбараас үзвэл, намын Их хурлын товыг 14 хоногийн өмнө зарлана гэсэн тус намын Улс төрийн зөвлөлөөр баталгаажуулсан журмын заалт зөрчигдсэн гэж үзэхээр байна.

б/ Их хурлыг зохион байгуулах удирдамжийг 2020.12.12-ны өдөр гаргаж, үүнд, хурлын төлөөлөгчдийн тоог 1400 гэсэн боловч хурлын тэмдэглэлд 1432 буюу 100 хувийн ирцтэй гэсэн атлаа 1206 гэсэн, тооллогын комиссын тогтоолд 1432 төлөөлөгч оролцохоос 1018 санал хураалтад оролцов гэж заасан нь Их хуралд оролцох болсон, түүнчлэн оролцсон төлөөлөгчдийн тоо зөрүүтэй байна.

Дүрмийн 5.12.3-т “Их хурлын төлөөлөгчид нь сонгогдох, томилогдох зарчмаар бүрдэх бөгөөд өөрөөр шийдээгүй бол Нийслэлд дүүргийн хороо тус бүрээс 2, аймагт 10000-аас дээш хүн амтай сумын баг бүрээс 1, бусад сумдаас тус бүр 1 төлөөлөгч сонгох ба Намын дарга, ҮБХ, ҮДХ, ДоСХ-ны гишүүд, намын дэргэдэх байгууллагын гүйцэтгэх удирдлага томилогдоно,

Дүрмийн 5.13.2-т ҮБХ нь Үндсэн дүрэмд өөрөөр заагаагүй бол УИХ-ын Сонгуулийн тойргийн мандатын тоог 5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү тооны гишүүдтэй байна. Үүнээс 76-с доошгүй нь эмэгтэй, 76-с доошгүй нь 39-өөс дээшгүй насны гишүүдэд ногдоно,

Дүрмийн 5.13.3, 5.13.5-д ҮБХ-ны гишүүнийг тухайн аймаг, дүүрэгт ногдох УИХ-ын тойрог тус бүрийн хүрээнд нэр дэвшүүлж, харьяалагдах саналын эрх нь нээлттэй гишүүнээс сонгож, намын Их хурлаас батална. ...ҮБХ-ны гишүүний бүрэн эрх 4 жил байна,

Дүрмийн 5.21.4, 5.21.5-д-т Үндсэн дүрмийн хороо /цаашид ҮДХ гэх/ 15 гишүүнтэй, ...ҮДХ-д дэвшигчийг намын Их хуралд санал болгон батлуулна, бүрэн эрхийн хугацаа 4 жил байна,

Дүрмийн 5.22.5.6-д Дотоод сонгуулийн хороо /цаашид ДоСХ гэх/ 15 гишүүнтэй байна. Бүрэн эрхийн хугацаа 4 жил байна гэж тус тус заасан байна.

Мөн дүрмийн 7.1-д зааснаас үзвэл, Намын дэргэдэх байгууллагын удирдлагад Ардчилсан эмэгтэйчүүдийн холбоо, Ардчилсан Оюутны холбоо, Ардчилсан залуучуудын холбоо, Ардчилсан ахмадын холбоо багтаж байна.

Дүрмийн дээр дурдсан заалтуудаас, Ардчилсан нам /АН/-ын Их хуралд төлөөлөгчид сонгогдох болон томилогдох журамтай байна.

Дүрэмд зааснаар аймаг, сум, дүүргээс Их хуралд нийт 906 төлөөлөгч сонгогдохоор байгаа ч тогтоол, тушаалуудаар нийт 715 төлөөлөгч сонгогдсон, харин Говьсүмбэр, Дорноговь аймаг, Чингэлтэй, Налайх Сонгинохайрхан дүүргээс төлөөлөгч сонгож, нэрсийг ирүүлсэн гэх баримт хүсэлтэд хавсаргагдаагүй тул сонгогдон оролцох зарим төлөөлөгч тодорхой бус гэж үзнэ.

Түүнчлэн, ҮБХ-ны 385, ҮДХ-ны 15, ДоСХ-ны 15 гишүүн тус тус оролцохыг заасан хэдий ч тэдний нэрс тодорхойгүй байна.

Их хурал зохион байгуулах 2020.12.12-ний өдрийн удирдамжийн “зургаа”-д төлөөлөгч сонгох, мандат олгох зохион байгуулах хэсгийн 2-т “...анхан шатны байгууллагаас сонгогдсон төлөөлөгчдийн анкет, 3x4 харьцаатай зураг 2 хувь цээж зураг,

хурлын тогтоолыг аймаг /дүүрэг/-ийн нам дээр 12.10-ны дотор хүлээн авч, материалыг аймаг /дүүрэг/-ийн намаас хурал зохион байгуулах ажлын хэсэгт 12.13-ны өдрийн дотор хүргүүлсэн маягтын дагуу бөглөн [Demparty.an@gmail.com](mailto:Demparty.an@gmail.com) хаягаар ирүүлэх гэж заажээ. Төлөөлөгчийн талаархи мэдээлэл тодорхой байх удирдамжийн дээрх заалт хэрхэн биелэгдсэн ойлгомжгүй байна.

Иймээс хуралд сонгогдсон болон томилогдсон, оролцсон төлөөлөгчид хэн болох, хурлын товыг хэрхэн мэдэгдсэн нь тогтоогдоогүй гэж дүгнэв.

в/ Их хурлыг цахимаар хийсэн гэх боловч тухайн дэгийг ирүүлээгүйгээс хурал дэгийн дагуу явагдсан эсэхэд дүгнэлт хийх боломжгүй. Тухайлбал, хурлын төлөөлөгч нарыг хэрхэн бүртгэсэн, үүнийг хэрхэн баримтжуулсан, хэлэлцсэн асуудлаар тооллого яаж явагдсан талаар дүгнэлт өгөх боломжгүй байна.

г/ Намын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа хэдэн хувьд нь нэмэлт, хэдэн хувийг хасч өөрчилсөн, найруулгын болон үг үсгийн өөрчлөлтөө ялгаж зааглаагүйгээс гадна хүчинтэй байгаа дүрмийн аль хэсэгт нэмэлт өөрчлөлтийг оруулснаа тодорхой тусгаж ойлгомжтой байдлаар баримтыг ирүүлээгүй болно.

д/ Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулахаар 2020.08.13-ны өдрийн намын даргын үүрэг гүйцэтгэгч Ц.Тувааны тушаалаар ажлын хэсэг байгуулж ажилласан, ҮБХ-ны 2020.12.17-ны өдрийн 19/11 тоот тогтоолоор намын дүрэмд оруулах нэмэлт өөрчлөлтийн төслийг дэмжиж, ҮБХ-ны гишүүдийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын хамт Их хурлаар хэлэлцүүлэхээр болсон гэх боловч тухайн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийн талаар өмнө нь намын анхан болон дунд шатны байгууллагаар хэлэлцсэн, санал авсан эсэх, ҮБХ-ны хурлаар хэрхэн хэлэлцсэн нь тодорхойгүй байна.

Мөн Их хурлын тэмдэглэлд, саналын зөрүүтэй 37 заалтад санал хураасан, энэ талаар тооллогын комиссын тогтоолууд хавсаргасан гэж тусгагдсан боловч эдгээрийг шүүхэд ирүүлээгүй байна.

е/ Дээр дурдсан зөрчлүүдээс гадна нэмэлт, өөрчлөлтийг тусгаж ирүүлсэн дүрмийн зарим заалт нь 10 дугаар Их хурлын “дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах” тухай тогтоолоос зөрүүтэй байгааг тэмдэглэв.

Эдгээр дурдсан алдаагаа зассаны дараа дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг бүртгүүлэхээр шүүхэд дахин хандах эрхтэйг дурдах нь зүйтэй.

Хоёр. Ардчилсан нам /АН/-ын дарга С.Эрдэнэ 2020.12.25-ны өдрийн 01/325-10 тоот албан бичгээр Улсын Дээд шүүхэд 2020.12.28-ны өдөр /цахимаар/ ирүүлсэн хүсэлтдээ, “10 дугаар Их хурлын тэмдэглэл, шийдвэр зэргийг буцаан татах хүсэлтийг гаргаж байна. 10 дугаар Их хурлын бичиг баримтуудад намыг төлөөлөн дарагдсан тамга хүчингүй болсон, төлөөлөх эрх бүхий хууль ёсны этгээдийн гарын үсэг зурагдаагүй ...танай байгууллага хүлээн авч шийдвэрлэх боломжгүй нөхцөл үүссэн тул хүргүүлсэн баримтуудыг ...буцаан ирүүлнэ үү” гэжээ.

Ардчилсан нам /АН/-ын дарга С.Эрдэнэ 2020.12.30-ны өдөр 01/325-23 тоот албан бичгээр “...Ц.Тувааныг үүрэг гүйцэтгэгчээр цахим бүртгэлд бүртгэснийг өөрчилж залруулга хийж өгнө үү” гэсэн хүсэлт гаргасныг 2021.01.04-ний өдөр Улсын дээд шүүх хүлээн авчээ.

Ардчилсан нам /АН/-ын дарга С.Эрдэнэ 2021.01.11-ний 22 дугаартай албан бичгийг Улсын Дээд шүүхэд ирүүлснийг 2021.01.12-ний өдөр хүлээн авсан, уг бичигт “...дүрмийн өөрчлөлт, тэмдэглэл, шийдвэрийг буцаан авах хүсэлтийг дахин гаргаж байна” гэжээ.

Ардчилсан нам /АН/-ын даргын үүрэг гүйцэтгэгч Ц.Туваан 2021.01.04-ний өдрийн 01/01 тоот албан бичгээр “Ардчилсан намд тамга, тэмдгийн хяналтын дугаар олгох, мөн Ц.Тувааныг Ардчилсан намын даргын үүрэг гүйцэтгэгчээр томилогдсон тухай бичилтийг тус

намын улсын бүртгэлийн гэрчилгээн дээр тэмдэглэж өгнө үү” гэсэн хүсэлт гаргасныг Улсын дээд шүүх 2021.01.04-ний хүлээж авсан.

Ардчилсан нам /АН/-ын үүрэг гүйцэтгэгч Ц.Туваан “Ардчилсан намд тамга, тэмдгийн хяналтын дугаар олгох, мөн Ц.Тувааныг Ардчилсан намын даргын үүрэг гүйцэтгэгчээр томилогдсон тухай бичилтийг Ардчилсан намын улсын бүртгэлийн гэрчилгээн дээр тэмдэглэж өгнө үү, гэх хүсэлтийг танайд 2021.01.04-ний өдрийн 01/01 тоот бичгээр гаргасан тул үүний хариуг 2021.01.12-ны өдрийн дотор бичгээр өгнө үү” гэсэн 2012.01.11-ний 01/09 тоот албан бичгийг 2021.01.12-ны өдөр ирүүлжээ.

Ардчилсан нам /АН/-ын Хэрэг эрхлэх газрын даргын үүрэг гүйцэтгэгч А.Цэрэнбатаас 2021.01.05-ны өдрийн ХЭГ/04 тоот албан бичгээр “цаашид 2020.12.25-ны өдрөөс эхлэн 9020120477 дугаартай тамга, ХНТ4896 дугаартай тэмдгийг ашиглах тул мэдээллийн санд бүртгэж өгнө” гэсэн утгатай бичгийг ирүүлснийг Улсын Дээд шүүх 2021.01.08-ны өдөр хүлээн авсан.

Ардчилсан нам /АН/-ын дарга С.Эрдэнэ 2012.01.10-ны өдөр “...Улсын дээд шүүхийн цахим бүртгэлд Ардчилсан намын дарга “намын үүрэг гүйцэтгэгч Ц.Туваан” гэснийг “намын дарга С.Эрдэнэ” гэж өөрчилнө үү.” гэсэн 20 тоот албан бичгийг Улсын Дээд шүүхэд 2021.01.12-ны өдөр гаргасан байна.

Дээр дурдсан хүсэлтүүдийн агуулга нь Ардчилсан нам /АН/-ыг төлөөлөх эрхтэй этгээд, түүний улсын бүртгэл, намын тамга, тэмдгийн талаар байх тул эдгээрийг нэгтгэн дүгнэлт хийх нь зөв гэж үзэв.

## 2.1 Ардчилсан нам /АН/-ыг төлөөлөх эрхтэй этгээд, түүний бүртгэлийн талаар.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 4.1.6-д “хуулийн этгээдийн мэдээлэл гэж хуулийн этгээдийн хувийн хэрэгт агуулагдаж байгаа энэ хуулийн 10.1-д заасан болон бусад мэдээллийг хэлнэ” гэж, хуулийн 10.1.3-т “...хуулийн этгээдийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдийн оршин байгаа газрын хаяг, 10.1.10-т “хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагын овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, иргэний үнэмлэхийн хуулбар,...” гэж заасан байна. Энэхүү зохицуулалтаар хуулийн этгээд буюу намыг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг Улсын дээд шүүх бүртгэнэ.

Улсын дээд шүүхийн 2017.03.15-ны өдрийн 01 дугаар тогтоолоор Ардчилсан намын даргаар С.Эрдэнэ томилогдсоныг бүртгэж, энэ талаар улсын бүртгэлийн гэрчилгээнд бичилт хийсэн нь тогтоогджээ. Харин Ардчилсан нам /АН/-ын Хэрэг эрхлэх газрын дарга П.Нүрээдийн 2020.11.05-ны өдрийн 02/418 тоот Улсын дээд шүүхэд хандаж гаргасан “намын даргын үүрэг гүйцэтгэгчийг бүртгүүлэх” хүсэлт, тус намын ҮБХ-ны 2020.07.24-ний өдрийн 16/06 тоот тогтоолыг үндэслэн Улсын дээд шүүх цахим бүртгэлд намын даргын үүрэг гүйцэтгэгчээр Ц.Тувааныг бүртгэсэн байна.

С.Эрдэнийн зүгээс “...сонгуулийн дараа дүрмийн дагуу огцрох үндэслэл бий болсон, ...2020.06.26-ны өдөр ҮБХ-нд дүрэмд заасан журмын дагуу огцрох хүсэлтийг шийдвэрлэж өгөхийг хүссэн, намын ҮДХ 2020.07.03-ны өдөр 16 тоот тогтоолыг гаргаж, уг тогтоолоор намын дүрмийн зарим заалтыг хэрэгжүүлэхэд хоорондоо зөрчилтэйгээс намын хуучин дарга нь шинэ даргад эрх үүргээ шилжүүлнэ гэж дүрмийн зохих заалтыг тайлбарласан. ҮДХ-ны журамд зааснаар тус хороо дүрмийг зөв хэрэглэх талаар тайлбар гаргах эрхтэй, тайлбар нь дүрмийн заалтын нэгэн адил хүчинтэй гэж заасан. Миний хувьд ажлаа түр шилжүүлсэн, гэтэл зохих ёсоор гүйцэтгээгүй, ҮБХ-ны 2020.07.24-ний өдрийн 16/06 тоот тогтоолоор намын даргын үүрэг гүйцэтгэгчээр Ц.Тувааныг томилсон нь дүрмийн зохицуулалтыг зөрчсөн” гэж тайлбарлан, ҮДХ-ны 16 тоот тогтоол, Улсын Дээд шүүхийн 2017.03.15-ны өдрийн 01 тоот тогтоол, Ардчилсан нам /АН/-ын улсын бүртгэлийн гэрчилгээг үндэслэн өөрийгөө намын дарга гэж маргасан байна.

Ардчилсан нам /АН/-ын дарга С.Эрдэнэ нэмж, ҮБХ-ны 2020.07.24-ний өдрийн 16/06 тоот тогтоолыг хүчингүй болгож, Ц.Тувааныг намын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчээс чөлөөлсөн тухай ҮБХ-ны 2021.01.10-ны өдрийн 11 тоот тогтоол, уг тогтоол нь дүрмийг зөрчсөн эсэхийг шийдвэрлэсэн ҮДХ-ны 2021.01.11-ний өдрийн 03 дугаар тогтоолыг ирүүлжээ.

Ардчилсан нам /АН/-ын даргын үүрэг гүйцэтгэгч Ц.Туваанаас, 2020.06.26-ны өдөр ҮХД-д С.Эрдэнийн гаргасан “Ардчилсан намын үндсэн дүрмийн 3 дугаар бүлгийн 3.10.1, 3.10.1.1 дэх заалт, 5 дугаар бүлгийн 5.17.6.1 дэх заалт, Ардчилсан намын гишүүний ёс зүйн, сахилгын тухай журам”-ын 7 дугаар бүлгийн 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн Ардчилсан намын даргын ажлаас чөлөөлөгдөх дүгнэлтийг хэлэлцэн гаргаж өгнө үү” гэсэн хүсэлт, 2020.07.08-ны өдөр тамга хүлээлцсэн баримт, ажлаа шилжүүлж байгаагаа мэдэгдсэн видео бичлэг, ҮБХ-ны 2020.07.24-ний 16/06 тоот тогтоолыг гаргасан байна.

Намын дүрмийн 3.10.1-д “Ардчилсан нам нь УИХ-ын сонгуульд хамгийн олон суудал аваагүй тохиолдолд:

3.10.1.1-т Намын дарга, дэд дарга, намын ЕНБД-ыг огцорсонд тооцно.

3.10.1.2-т Намын Үндэсний бодлогын хороо нь УИХ-ын сонгуулийн санал хураалт явагдсан өдрөөс хойш 30 хоногийн дотор хуралдаж дараахь шийдвэрийг гаргана.

3.10.1.2.1-т намын дарга, дэд дарга, ЕНБД нарыг огцорсныг Үндсэн дүрмийн хороо /ҮДХ/-оос ажлын 5 хоногт албажуулсныг мэдээлэх,

3.10.1.2.2-т намын Их хурлыг УИХ-ын сонгуулийн санал хураалт явагдсан өдрөөс хойш 90 хоногт багтаан хийхээр товлох гэж тус тус заажээ.

Мөн дүрмийн 5.17.6-д Намын даргыг дараах үндэслэлээр ҮБХ-ны хурлаар чөлөөлж намын Их хурлыг зарлана. Энэ тохиолдолд намын дараагийн дарга сонгогдох хүртэл намын даргын эрх, үүрэг аль нэг дэд даргад шилжинэ. Үүнд:

5.17.6.1-д АН нь УИХ-ын сонгуульд хамгийн олон суудал аваагүй гэсэн байна.

Дүрмийн эдгээр зохицуулалт болон болсон үйл явцаас үзэхэд, намын ҮБХ-оос болон ҮДХ-оос намын даргын талаар хоорондоо зөрчилтэй тус тус өөр агуулгатай шийдвэр гаргасан байна.

Улс төрийн намын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.9-т “намын дүрмээр зохицуулах намын дотоод зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбоотой маргааныг шүүх шийдвэрлэхгүй. Энэхүү маргааныг намын эрх бүхий байгууллага хянан шийдвэрлэнэ” гэж, мөн хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “намын үйл ажиллагаанд намын хяналтын байгууллага хяналт тавина” гэж тус тус заасан байна.

Иймд Ардчилсан нам /АН/-ыг төлөөлөх эрхтэй этгээд, түүнийг улсын бүртгэлд бүртгүүлэх асуудал маргаантай гэж үзэж Ц.Тувааныг намын даргын үүрэг гүйцэтгэгчээр цахим бүртгэлд бүртгэснийг хасч, бусад хүсэлтүүдийг хангахаас татгалзах нь хуульд нийцнэ гэж дүгнэв. Намын дарга, түүнийг төлөөлөх этгээдийн талаар нам дотооддоо шийдвэрлэж, бүртгэл хийлгэхээр дахин хандах эрхтэй ба харин намыг төлөөлөх эрхтэй этгээдийн бүртгэл цахим мэдээлэлд тодорхой бус үлдсэн болохыг дурдав.

Ардчилсан нам нь одоогийн байдлаар хоёр өөр байранд зэрэгцэн үйл ажиллагаа явуулж байгаа нь тогтоогдсон тул Ардчилсан нам /АН/-ын дарга С.Эрдэнийн гаргасан ҮБХ-ны 2020.07.24-ний өдрийн 16/06 тоот тогтоолыг хүчингүй болгож, Ц.Тувааныг намын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчээс чөлөөлсөн тухай ҮБХ-ны 2021.01.10-ны өдрийн 11 тоот тогтоол, уг тогтоол нь дүрмийг зөрчсөн эсэхийг шийдвэрлэсэн ҮДХ-ны 2021.01.11-ний өдрийн 03 дугаар тогтоолыг хүчинтэй эсэхэд дүгнэлт хийх боломжгүй гэж үзсэн болно.

2.2 Тамга, тэмдгийн хяналтын дугаар олгох болон тамга, тэмдгийг мэдээллийн санд бүртгэх асуудлаар.

Ардчилсан нам /АН/-ын өмнө ашиглаж байсан тамга, тэмдгийн 1117237845 хяналтын дугаартай тамгыг Улсын бүртгэлийн ерөнхий газрын хяналтын улсын байцаагчийн 2020.12.24-ний өдрийн 6030 дугаар дүгнэлтээр хүчингүй болгосон, Улсын бүртгэлийн ерөнхий газраас тус намд 9020120477 тоот тамга, тэмдгийн хяналтын дугаар олгогдсон одоо ашиглагдаж байгаа нь тус тус тогтоогджээ.

Ц.Туваан хүсэлтдээ, "...тамга, тэмдгийн хяналтын дугаар нөхөн авах шаардлага бий болсон, хяналтын дугаар олгоно уу" гэж, С.Эрдэнэ хүсэлтдээ, "...тамга, тэмдгийг ...мэдээллийн санд бүртгэж авна уу" гэсэн байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9, 8.10, 8.11-д зааснаар тамга, тэмдгийн хяналтын дугаарыг хүчингүй болгох, дахин олгох, тамга, тэмдэг хийлгэх, үйл ажиллагаанд хяналт тавих ажиллагааг Улсын бүртгэлийн ерөнхий газар хариуцах чиг үүрэгтэй байна.

Иймээс тамга, тэмдэгтэй холбоотой маргааныг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх нь зүйтэйг дурдаж, эдгээр хүсэлтийг хүлээн авахаас татгалзав.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.4, Улс төрийн намын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасныг удирдлага болгон ТОГТООХ НЬ:

1. Ардчилсан намын /АН/-ын дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг бүртгэхээс татгалзсугай.
2. Улсын Дээд шүүхийн цахим бүртгэлд Ц.Тувааныг Ардчилсан нам /АН/-ын даргын үүрэг гүйцэтгэгчээр бүртгэснийг хассугай.
3. Улсын Дээд шүүхийн цахим бүртгэлд Ардчилсан нам /АН/-ын даргаар бүртгүүлэх С.Эрдэнийн хүсэлтийг хангахаас татгалзсугай.
4. Ардчилсан нам /АН/-ын даргын үүрэг гүйцэтгэгчээр томилогдсон тухай тус намын улсын бүртгэлийн гэрчилгээнд бичилт хийлгэх Ц.Тувааны хүсэлтийг хангахаас татгалзсугай.
5. Ардчилсан нам /АН/-ын тамга, тэмдгийн хяналтын дугаар дахин олгох болон тамга, тэмдгийг мэдээллийн санд бүртгэх С.Эрдэнэ, Ц.Туваан нарын хүсэлтийг хүлээн авахаас татгалзаж, энэ асуудлаар хүсэлт гаргагч нар холбогдох байгууллагад хандах эрхтэйг дурдсугай.

ТАНХИМЫН ТЭРГҮҮН

Х.СОНИНБАЯР

ШҮҮГЧИД

П.ЗОЛЗАЯА

Г.АЛТАНЧИМЭГ